

## Г.Цэндоржийн Прелюди ба фуга (дэс.59)-ийг хөгжимдөх арга барил

Алтансүхийн Энх-Амгалан ✉ 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ amgln13@gmail.com

Баянжаргалын Оюунбадрах 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Өрнийн сонгодог хөгжимд бүрэлдэн бий болсон олон хоолойн хөгжмийн дээд хэлбэр болох фуга нь монголын сонгодог хөгжимд анхлан сурах бичиг хэлбэрээр танигдсан. Үүнийг “Олон хоолойн ухаан” I дэвтэр “Чанд бичлэгийн контрапункт” (1974), “Олон хоолойн ухаан” II дэвтэр “Фуга” (1979) нэртэйгээр Д.Жанчив зохиож олны хүртээл болгожээ. Харин анхны хөгжмийн зохиолыг Г.Цэндорж төгөлдөр хуурт зориулж Прелюди ба фуга дэс.59 №1, 2, 3, 4 (1979), №1, 2, 3 (1986) гэсэн нийт долоон Прелюди ба фугийн хослолыг зохиосон байна. Тус дэс.59 №1, 2 зохиолыг сонгодог уламжлалт Прелюди ба фугатай уялдуулан бүтэц, хэлбэрийг олох, хөгжимдөх гарын тавил, хурууны дугаарын сонголт, хөгжмийн дүрслэлийг илэрхийлэхэд гарах хүндрэлийг даван туулах, хэрхэн хөгжимдөх арга барилыг судалж тодруулахыг зорьсон. Ингэснээр зохиолыг эргэлтэнд оруулах, мэргэжлийн хөгжмийн урлагт ач холбогдолыг нээн илрүүлэх ач холбогдолтой. Судалгаанд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглалтын ерөнхий аргуудаас болон хөгжмийн зохиолыг хөгжимдөх арга барилд суурилан судалж тодрууллаа.

**Түлхүүр үгс:** олон хоолой, хөгжмийн зохиол, хөгжимдлөг, боловсруулга, төгөлдөр хуурч

### Performing Methods of the G.Tsendorj's Prelude and Fuga op. 59

Enkh-Amgалан Altansukh ✉ 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture  
Ulaanbaatar, Mongolia  
✉ amgln13@gmail.com

Oyunbadrakh Bayanjargal 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** The fugue, one of the greatest achievements of Western classical polyphony, is recognized as the foundation of academic transcript of polyphony in Mongolia. The first textbook, *Strict Counterpoint (Book 1)*, was published in 1974, followed by *Fugue (Book 2)* in 1979, both written by Janchiv D. In addition, the first Mongolian compositions in this genre, a cycle of *Preludes and Fugues* (nos. 1–4, 1976; nos. 1–2, 1986), were created by G. Tsendorj, comprising a total of seven pairs of preludes and fugues. Within Op. 59, Nos. 1 and 2, each composition is structured in close relation to the classical tradition of the prelude and fugue. Their form and construction are analyzed with attention to performance technique, including hand positioning, fingering choices, and methods of overcoming difficulties in conveying musical imagery, with particular focus on effective interpretation and performance practice. Thus, the significance of bringing the composition into circulation and its contribution to professional musical art is revealed. The study was conducted using general research methods such as analysis, synthesis, and observation, and was further clarified through an examination based on performance practices of musical compositions.

**Keywords:** *counterpoint, musical composition, perform, editing, pianist*

### Оршил

Дэлхийн олон орон үндэстэн, ястны дуу хөгжмийн түүхэн байдлаас үзэхэд эртний хүн бодсон санаснаа аялан илэрхийлж эхлэхдээ дан хоолойгоор эхэлсэн нь тодорхой. Дан хоолойн төрх нь ардын дууны төрөлд их таарах бөгөөд мэргэжлийн хөгжмийн эртний төрлүүд дан хоолойгоор илэрч байв. Хүн төрөлхтний хөгжлийн явцад (дундад зууны үеэс) дан хоолойн арга чамлагдан хөгжмийн утга санааг олон хоолойн дуугаралтаар илэрхийлэх болсон. Олон хоолойн бүрдэлтийн анхны хэлбэрүүд X-XII зуунд ардын хөгжимд үүсэж улмаар мэргэжлийн хөгжимд нэвтрэн олон зууны турш хөгжиж ирсэн ба ингэхдээ олон хоолойн тогтолцоо хоолойнуудын харьцаа, агуулгаас шалтгаалан Гомофон<sup>1</sup> (Жанцанноров 1996, 25), Гетерофон<sup>2</sup> (Жандал 2006, 6), Полифон<sup>3</sup> (Жанчив, 1974) гэсэн үндсэн гурван бүтцээр хөгжсөн байна. Харин И.С.Бах “Жигдэлсэн хөгт даруулт хөгжим” хэмээх тус бүр 24 прелюди ба фугаас бүтсэн хоёр боть зохиолыг 1722-1744 оны хооронд туурвисан нь фугийн хөгжлийн дээд шат болжээ (Жанчив 1974, 10).

Манай улсад өмнө нь дурдсанчлан олон хоолойн онолын талаар анх хөгжмийн багш Д.Жанчив судлан бичиж, хөгжим судлаач Т.Жандал “Олон хоолойн ухаан”, I дэвтэр “Онолын үндэс” (2006) номыг тус тус орчуулан эмхэтгэн гаргасан нь энэ хөгжмийн хэлбэрийг бүрэлдэн бие болох суурийг тавьсан байна. Харин анхны Прелюди ба фуга зохиолыг Г.Цэндорж 1979 онд Прелюди ба фуга Дэс.59 №1, 2, 3, 4, 1986 онд №1, 2, 3 нийт 7 зохиол бичсэний эх хувь Монгол Улсын консерваторын номын санд хадгалагдан үлдсэн байна. Б.Оюунбадрах “Мэргэжлийн хөгжмийн боловсруулга” төслийн хүрээнд 2019 онд тус зохиолуудыг боловсруулан хэвлэн

<sup>1</sup> Хоолой бүрийг гол, хамсрах байдлаар хуваасан олон хоолойн төрөл

<sup>2</sup> Гол аялуут хоолой түүний ижил хувилбаруудтай нэгдэж дуурьсах олон хоолойн төрөл

<sup>3</sup> Хамтран дуурьсахдаа нэг нь нөгөөгөөс гоц ялгарагч, бие биеэсээ үл хамаарагч хоолойнуудаас бүрдсэн олон хоолойн төрөл

гаргасан. 2015 онд Б.Золзаяа магистрын уран бүтээлийн хамгаалалтад Прелюди ба фуга Дэс.59 №1 хөгжимдсөнөөс өмнө тус зохиолыг хөгжимдсэн төгөлдөр хуурч бараг үгүй бөгөөд сүүлийн 10 жилд тус зохиол нь сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж эхэлсэн. 2022 онд тус зохиолыг өгүүллийн зохиогч /А.Энх-Амгалан/ хөгжимдөж дүржүүлэн олон нийтийн сүлжээнд байршуулсан. Тус дэс.59 №1, 2 зохиолыг сонгодог уламжлалт Прелюди ба фуга-тай уялдуулан бүтэц, хэлбэрийг олох, хөгжимдөх гарын тавил, хурууны дугаарын сонголт, хөгжмийн дүрслэлийг илэрхийлэхэд гарах хүндрэлийг даван туулах, хэрхэн хөгжимдөх арга барилыг судалж тодруулахыг зорьсон. Ингэснээр зохиолыг эргэлтэнд оруулах, монголын мэргэжлийн хөгжмийн урлагт ач холбогдолыг нээн илрүүлэх юм. Дэг жаяг бүхий И.С.Бахын Прелюди ба фуга зохиолын арга техник, бүтэц, бүрэлдэхүүнтэй харьцуулан жишиж өөрийн хөгжимдсэн арга туршлага дээр тулгуурлан зохиолын эх хувийг ашиглан эдгээр зохиолыг хэрхэн хөгжимдөх арга барил, тайлбарлалын асуудлыг хөндсөн болно. Хөгжимдөх нэр томъёоны хувьд Н.Жанцанноров, Д.Жанчив, Б.Оюунбадрах нарын оноосноор судалгаандаа хэрэглэсэн ба Фугийн бүтцийн онолын нэр томъёоны хувьд “противосложение”-г Д.Жанчив “Тэсрэг ахуй ая” (Жанчив 1976, 18), Н.Жанцанноров “Эсрэг тавил” (Жанцанноров 1996, 78), Т.Жандал “Эсрэг аялгуу” (Жандал 2006, 42) гэснийг эсрэг сэдэв гэж өөрийн оноосноор, “интермеди”-г Д.Жанчив “Зааглац хэсэг”, Т.Жандал “Завсарлага”, Н.Жанцанноров “Завсар хөгжим” гэснийг Н.Жанцанноровын оноосноор тус тус авч хэрэглэсэн болно.

### **Судалгааны арга зүй**

Судалгааны хүрээнд эх хувилбарыг эрж хайн адил төст хуулбарыг ялгаж салган, хэрэглэгдэх эх хэрэглэгдэхүүнийг цуглуулах, түүнд боловсруулалт хийн, задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, ажиглалтын ерөнхий аргуудаас болон хөгжмийн зохиолыг хөгжимдөх арга барилд суурилан судалж тодрууллаа.

### **Судалгааны ажлын үр дүн**

Олон хоолойн үүслийн түүхийг товч авч үзвээс, анхны хэлбэрүүд Х-ХII зуунд бий болж, ХIII-ХIV зуунд хоолойн тоо нэмэгдэж, гурван хоолойн дуугаралт харьцангуй илүү тархаж 4-6 хоолой бий болсон байна. Полифони бүтэц бий болохын зэрэгцээ имитаци (дуурайх), давхар контрапункт зэргийг анх удаа хэрэглэж эхэлсэн. ХV-ХVI зуунд хөгжмийн онолд чанд бичлэгийн үе бий болж дуулаачийн хөгжмийн төрөлд дээд зэрэгт хүртлээ хөгжсөн ба полифони нь олон хоолойн голлох бүтэц болон төлөвшиж өөрийн бүх онцлог шинж чанарыг агуулсан хөгжмийн илэрхийллийн гол зарчим болов (Жандал 2006, 7). Утга санааг дан хоолойгоор илэрхийлэх аргаас олон хоолойд шилжсэн явдал нь урлагийн энэ төрлийн хувьд том хувьсал байсан шиг чанд бичлэг, түүний гол хэлбэр-имитаци чөлөөт бичлэгээр солигдож, цаашлаад олон хоолойт хөгжмийн дээд хэлбэр фугийг бий болгосон нь хөгжмийн түүхэнд том ололт амжилт байлаа. Фуга гэх нэр томъёо нь дундад зууны үед хэдийн ашиглагдаж байсан боловч энэ дуураймал буюу нэг хоолой дахь аялгууг хааяа давтахад, дараа нь тусдаа хөгжмийн хэлбэрүүд болох канон (хуулбарлах) болон бусад төрлийн бүтээлд илэрч байв. Өнөөдөр бидний мэдэх фуга хэлбэр нь ХVI зуунаас дууны болон дан хөгжмийн аль алинд хөгжиж

эхэлсэн. Энэ төрөлд жинтэй хувь нэмэр оруулсан хүмүүс бол италийн хөгжмийн зохиолч Жованни Пьерлуизи Палестрина (Месса-д имитациар ашигладаг), германы хөгжмийн зохиолч Иоханн Себастиан Бах, Георг Фридрих Хендель (ихэвчлэн Магтуудаа ашигладаг) нар юм. Бах, Хендель нараас хойш fuga дан хөгжмийн хэлбэрийн хувьд зонхилох байр сууриа алдсан боловч ач холбогдол нь огтхон ч бууралгүй бусад хэлбэрүүдтэй хамт оршин өдийг хүрсэн билээ.

Прелюди ба фугийн хослол нь гол төлөв ижил дэвсгэр хөгт бичигдсэн хоёр ангитай гоцлол даралтат хөгжимд зориулсан олон хоолойн хөгжмийн хэлбэр юм. Сонгодог хөгжимд прелюди ба фугийн хослол нь олон жилийн түүхтэй. Хэдийгээр “Жигдэлсэн хөгт клави́р” бол бүх 24 хөгт бүрэн боловсруулсан даралтат хөгжмийн анхны бүтээл байсан ч үүнтэй төстэй санаанууд өмнө нь гарч байсан. Жишээбэл, Иоганн Кристиан Шикхардт (1681–1762) Op.30 “L’alphabet de la musique” (Цагаан толгойн цомог) (1735 оны орчим) нь лимбэ, хийл, basso continuo-ийн бүх хөгт 24 сонат агуулсан байв (Drummond Pippa, Lasocki David 2001, 5). Цаашилбал, Бахаас 200 орчим жилийн өмнө lute<sup>4</sup> /Лютня/, theorbo<sup>5</sup> /Теорба/ гэх мэт чавхдаст хөгжмийн зэмсгүүд дээр ижил төстэй төлөв ажиглагдаж, бүх хөгт хэд хэдэн түүвэр бий болсон. Жиаккомо Горзанис<sup>6</sup> “Пассамеццо<sup>7</sup>–Сальтарелло<sup>8</sup>-ийн 24 хос цуврал” (1567), Винченцо Галилей<sup>9</sup> “24 бүлэг бүжиг” (1584), Жон Вилсон<sup>10</sup> Лютя хөгжмийн гоцлолд зориулж 30 прелюди, Даниел Кронер “Орган хөгжимд зориулж цуврал прелюди” (1682), Иоганн Хайнрих Киттель дараалсан хөгөөр органд зориулж 12 прелюди, Иоганн Каспар Фердинанд Фишер<sup>11</sup> “Ariadne musica neo-organoedum” арван их хөг, есөн бага хөг бүхий 20 прелюди ба фугийн багц зохиол, Иоганн Маттесон (1681–1764)-ийн “Exemplarische Organisten-Probe” (1719) зохиолыг figured bass (Генерал-бас)-д зориулж бүх хөгт 48 дасгал бичсэн байна (Geiringer 1954, 268-269).

Харин прелюди хэмээх төрөл нь Барокко үеэс үүссэн ба ихэвчлэн хэмжээний хувьд жижиг бөгөөд том хөгжмийн зохиолын оршил, эхлэл болон тоглогдож ирсэн. Энэ нэр томъёог ерөнхийд нь шашны болон шашны зан үйлийн өмнөх аливаа бүтээл, тэр дундаа зарим тохиолдолд дуурийн тоглолт зэрэгт ашиглаж ирсэн. И.С.Бах өөрийнхөө хөгжмийн бүтээлд прелюди хэмээх төрлийг фугийн өмнөх бэлтгэл маягаар оруулж Шопен прелюди бүтээлийг бие даасан жижиг хэлбэрт оруулсан нь энэхүү бүтээлийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. И.С.Бах прелюдийг олон төрлүүдтэй нэгтгэж уран бүтээлдээ чухалчлан үзсэн байдаг. Түүний прелюди бүр өөрийн гэсэн өвөрмөц шинж чанартай, зарим нь аритай, зарим

<sup>4</sup> Нэг төрлийн цөөхүүл хөгжмийн бүрэлдэхүүн

<sup>5</sup> Lute (Поль.Lutnia) Маш эртний чавхдаст хөгжмийн зэмсэг, гарал үүсэл тодорхойгүй, Египет, Хитийн хаант улс, Грек, Ром, Болгар, Хятад, Киликийн соёлд эрт дээр үеэс уг зэмсгийн төрөл бүрийн хувилбарууд ашиглагдаж ирсэн байна.

<sup>6</sup> Лютня хөгжмийн зэмсгийн басс төрөл

<sup>7</sup> Giacomo Gorzanis (1520-1575/79) – Италийн хөгжмийн зохиолч, Лютня хөгжимчин


<sup>8</sup> (Итал. Passamezzo) XVI-XVII зууны үеийн Итали ардын бүжиг

<sup>9</sup> (Итал. Saltarello) Италиас гаралтай хөгжимт бүжиг, Пассамеццо бүжгийг дагалддаг гурван бүжгийн нэг

<sup>10</sup> Vincenzo Galilei – Италийн хөгжмийн зохиолч, онолч, лютня хөгжимчин

<sup>11</sup> John Wilson – Английн хөгжмийн зохиолч, багш, лютня хөгжимчин

нь бүжгийн хэлбэртэй, токката болон инвенцитэй гэх мэт. Энэ жишээнд токката ба fuga, уран сэтгэмж ба фугийг дурдаж болно. Иохан Пахальбель прелюди ба фугийг холбоход анхдагч байсан ч Бахын прелюди илүү алдартай болсон. Үүнээс хойш олон хөгжмийн зохиолчид энэ төрөлд бүтээл туурвисан. Тэдгээрээс Зөвлөлт оросын хөгжмийн зохиолч Д.Шостаковичийн 24 прелюди ба fuga амжилттай болж богино хугацаанд сургалт, концертын үйл ажиллагаанд байр сууриа эзлээд байна.



Зураг 1. Эх бичвэр, 1979

Манай оронд хөгжмийн зохиолчид дан төгөлдөр хуурын прелюди төрөлд зохиол олноор бичсэн байдаг. С.Гончигсумлаа төгөлдөр хуурт зориулсан “24 прелюди” (1978-1979), “Прелюди токката хувилбар” (1985), Мөрдорж цуврал прелюди, Ч.Сангидорж прелюди 50 гаруй, З.Хангал хийл төгөлдөр хуурт зориулсан прелюди №1, 2, 3 (1969), төгөлдөр хуурт зориулсан прелюди №1, 2 (1969), “Түрүү магнай” прелюди (1970), Прелюди №1, 2, 3 (1985) гэх мэт хөгжмийн зохиолч бүрт цөөнгүй бий, харин прелюди ба фугийн хослол харьцангуй цөөн юм. Энэ төрөлд Г.Цэндорж анхдагч болох ба хөгжмийн зохиолч Х.Мөнх-Ертөнц 24 прелюди ба fuga 2004-2021 оны хооронд зохиосон хэмээн урын сангийн жагсаалтдаа тусгажээ<sup>12</sup>.

Г.Цэндорж нь нийт долоон прелюди ба фугийг 1979 онд дэс.59 №1, 2, 3, 4 болон 1986 онд №1, 2, 3 хэмээн тус тус зохиосон. 1979 онд зохиогдсон дөрвөн прелюди fuga нь зохиолчийн өөрийн сэдэв аялгуу, 1986 онд зохиогдсон гурван прелюди ба fuga нь ардын дууны аялгуунаас сэдэв авчээ. Үүнээс дэс.59 №1, 2-р прелюди ба фугийг хөгжимдөх арга барилыг авч үзье. Цаашид зохиолын дугаар болон хөгөөр нэрлэж явна.

1. Прелюди ба fuga №1 Ми мажор (1979)
2. Прелюди ба fuga №2 Соль минор (1979)

*Хүснэгт 1. Фугийн бүтэц, задаргаа*

Фуга	E dur	G moll
Сэдэв ая	2 айзам	2 айзам
Бодит хариу	Доминангийн гоц өрөгт дунд хоолойд эхэлнэ.	Доминантын гоц өрөгт дунд хоолойд эхэлнэ.
Бараг хариу	-	Айзам 7-14
Түрэл (стретта)	-	Айзам 8, 10
Хавчаас аялгуу	байгаа	-

<sup>12</sup> 24 Прелюди ба fuga нь ноот болон хэвлэгдээгүй байна.

Эсрэг сэдэв (Противосложение)	1. Үндсэн сэдэв аяны хэвийн үргэлжлэл болж чадсан. 2. Өгсөх уруудах зэрэгцээ хэмнэлийн хувьд ялгарч байна. 3. Дуурьслын хувьд харшлахгүй, хариунаас шууд шалтгаалсан. 4. Эс тогтонгуй эсрэг сэдэв аятай.	1. Үндсэн сэдэв аяны хэвийн үргэлжлэл болж чадсан. 2. Өгсөх уруудах зэрэгцээ хэмнэлийн хувьд ялгарч байна. 3. Дуурьслын хувьд харшлахгүй, хариунаас шууд шалтгаалсан. 4. Эс тогтонгуй эсрэг сэдэв аятай.
Завсар хөгжим (интермеди)	4 айзам (6-9)	1. Сэдэв аяыг давтах агаад бараг хариугаар 8 айзам (7-14) бичигдсэн. 2. Өөрчлөлттэй сэдэв ая 4 удаа давтагдана.
Удиртгал бүлэг (экспозиция)	5 айзам (1-5)	6 айзам (1-6)
Дэд удиртгал	-	-
Завсрын бүлэг	6 айзам (10-15)	
Төгсгөл бүлэг	10 айзам (16-25) Үндсэн хөг дээр доминантын гоц өргөөс эхлэн дунд болон дээд хоолойд тоглогдоно.	4 айзам (31-35) Удиртгалын сэдэв аяыг давталгүй, шинэ сэдвээр соль мажорт төгсөнө.


Тус хоёр прелюди fuga нь дүрслэл, илэрхийллийн хувьд эсрэг тэсрэг бөгөөд төгөлдөр хуурчаас өөр өөр дүр, эгшиглэгээ, хөгжимдөх чадвар шаардана. Уламжлалт прелюди ба фугийн бүтцээр бичигдсэн. И.С.Бахын фугийн бүтэцтэй харьцуулбал, фугад байх бүх бүтэц хэлбэр, арга техник адил байна.

*Хүснэгт 2. Хурд, дүрслэл илэрхийллийн харьцуулалт*

Хурд буюу дүрслэл илэрхийлэл			
Прелюди ба fuga ми мажор		Прелюди ба fuga соль минор	
Прелюди	Fuga	Прелюди	Fuga
Allegretto	Moderato	Allegretto	Andante

Прелюди ба fuga №1 ми мажор: Прелюди ми мажор, хурд Allegretto буюу Мельцелийн Метрономоор 108-тай тэнцүү. Нийт 29 айзам үргэлжилнэ. Зохиолын цомнолыг задлан шинжилбэл, пентатоник хийгээд түүний 3-р хэв шинж ажиглагдаж байна (1,1,1.5,1,1.5 шат). Прелюдийн эхлэл цоглог, хөгжүүн наймт арван зургаатын хэмнэлийг ашиглах бөгөөд нэгэн жигд урссан, зүүн гарт өргөлттэй /акцент/ наймт ноот гоц өрөг болон тавцын эгшиг дээр, 3-р айзмаас зохиолын аялгуу зүүн гарт шилжиж хагас шатаар уруудан хөдлөх ба аялгууг холбож аялгууны хөдөлгөөний эвдэхгүй хөгжимдөх ёстой. Харин баруун гар дагалдах үүргийг гүйцэтгэж байна. Гоцлооч эхний 2 айзам дуурьсгуур ашиглахгүй байх нь зохистой, харин баруун гарын үргэлжилсэн наймт, арван зургаат хэмнэлд ноотны алдагдал, үргэлжилсэн

жигд хөдөлгөөнд хуруу бүдрэх магадлал өндөр учир 4, 5-р хурууны тасралтгүй хөдөлгөөнийг бие болгоход зөв давталт шаардлагатай байна.



Зураг 2. Баруун гарын жигд хөдөлгөөн айзам 1-4, зүүн гарын аялгуу айзам 3


17-р айзмаас зохиолын 2-р хэсэг эхлэх ба эхний аялгууг 5 айзам буюу 21 айзмын 3-р хувь хүртэл давтана. Ингэхдээ 1-р айзамд *mf* (дунд зэрэг чанга) байсан бол энэ удаад *ff* /маш чанга/ хэмээн зохиолч тэмдэглэсэн байна. “Маш чанга” эгшиглүүлэхийн тулд 15-16-р айзмаас бэлдэж орох нь зөв байна. Зүүн гарт уруудсан дөрөвт ноотууд нь дараалал бүрд өнгө нэмэгдэж 8 удаа эгшиглэхдээ 8 удаа чангарна гэсэн үг.



Зураг 3. Айзам 15-18, 2-р хэсгийн эхлэлийн бэлтгэл болон 2-р хэсэг эхлэл

Ингэж 22-р айзмаас аялгууны хөдөлгөөн өөрчлөгдөн баруун гарт арван зургаат, зүүн гарт стаккато наймт болон хагас шатлалаар уруудсан дөрөвт ноотууд үргэлжлэн 28-р айзамд (зохиолчийн тэмдэглэсэн хүчдэлийн тэмдгийн дагуу) маш чанга (*ff*) хөгжимдөж хүчирхэг өргөлттэй хам эгшгүүд (аккорд) нэг, хоёр, гурав дугаар хувь дээр дуурьсаж эрч хүчтэйгээр төгсөнө. 28-р айзамд гэнэт маш чанга дуурьсуулахын тулд 27-р айзмаас дууны хүчийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Айзам 13-ын 3, 4-р хувь, айзам 21-ийн 3, 4-р хувийн хуваарилал /аппликатура/ нь европын сонгодог үеийн хөгжмийн зохиолч нар болох Гайдн, Моцарт, Бетховен, Шуберт цаашлаад романтизмын үеийн Шопен, Мендельсон гэх мэт зохиолчдын

бүтээлтэй харьцуулахад харьцангуй өөр хийгээд аливаа дөрвөн арван зургаатын дараалсан ноотууд дараагийн дараалалд шилжихэд 1-5 хүртэлх хуруу бүхэл байрлалд тоглогдох шаардлага гардаг. Энэ нь нь пентатоник цомлолоос шалтгаалж хурууны хуваарилалд өөрчлөлт орж байгаа нь гарцаагүй боловч зохиолын аялгуу хөдөлгөөний барил ч мөн үүнд нөлөөлж байна.



Зураг 4. Айзам 13, 5 хурууны багц байрлал




Зураг 5. Айзам 21, 5 хурууны багц байрлал

Харин 19, 20 зууны зарим хөгжмийн зохиолчид болох Ф.Лист, С.Прокофьев нарын зохиолд 5 хурууны хуваарилал нэлээд ажиглагддаг.

Фуга (ми мажор): 3 хоолой, хурд Moderato, 4/4 хэмжээтэй, сэдэв ая нэг дэвсгэр хөгийн, 2 айзмаас бүтсэн. Сэдэв ая зохиолчийн өөрийн аялгуу бөгөөд дээрээс доош уруудсан уянгалаг, эргэлдсэн хөдөлгөөнтэй. Мөн пентатоник цомлолын 3-р хэв шинж илэрч байна.

Си-соль-си-соль гэх наймтаар холбохдоо төгөлдөр хуурч хэтэрхий их ноот болгонд ач холбогдол өгч сарвууг займчиж үл болно. Тэгвээс аялгуу ноот бүрээр тасарна, харин дээд зэргийн “мэдрэмжтэй” хуруугаар аялгууг холбох хэрэгтэй, ингэхийн тулд 4-р хуруугаар эхэлж цааш 2, 4 гэх мэт үргэлжлүүлнэ. Өрнийн сонгодог зохиол мэт хөгжимдөж болохгүй, монгол аялгууны эгшиглэгээг сайн мэдрэх нь чухал. Хэтэрхий уянгалабал мөн утга алдагдах талтай. Аялгууны зураглалыг сайн анзаарах хэрэгтэй, түүний дагуу дуугаралтын чанга сулыг тааруулах нь зөв.



Зураг 6. Айзам 1. Фуга сэдэв ая



Зураг 7. Сэдэв аяны зураглал, дээрээс доош хөдөлгөөн, айзам 1-2

Эхний сэдэв ая дунд хоолойд эхэлж хариу нь доод хоолойд үргэлжилнэ. Хариу бодит хариу байх бөгөөд ямар нэгэн өөрчлөлтгүй үндсэн хөгийн гоц өрөгт эгшиглэнэ. Гурав дахь сэдэв ая холбогдохын өмнө хавчаас аялгуу дөрөвдүгээр айзмын нэг, хоёрдугаар хувьд дөрвөн бүлэг арван зургаатын хавчаас аялгуу залгаж дээд хоолойд бодит хариу гоц өрөгт залгана. Түрэл (стретта) байхгүй. Эсрэг сэдэв (противосложение) үндсэн аялгууны хэвийн үргэлжлэл болж чадсан, өгсөх уруудах зэрэгцээ хэмнэлийн хувьд ялгарч чадсан, мөн дуурьслын хувьд сэдэв аялгуунд харшлахгүй хариунаас шууд шалтгаалсан. Хариуны дэвсгэр хөг ми мажорт шилжихэд эсрэг сэдэв ч дагалдан ми мажорт шилжиж байна.

Тус зохиолын хувьд гарт эвтэй, монгол хөг аялгууны сэтгэлгээг бүрэн агуулсан ба төгөлдөр хуурчийн эгшиглээ (тембр) уран яруу хөгжимдлөгийг шаардсан зохиол юм.

Прелюди ба фуга №2 соль минор: Хурд Allegretto буюу хөнгөн, хөгжилтэй, ямар нэгэн хэлбэрт баригдаагүй бөгөөд цувраа (арпеджио)-аар аялгуу эгшиглэнэ. Үндсэн хөг соль минорт эхэлж олон удаа хөг шилжих ба соль мажорт төгсдөг (соль минор - до минор - фа минор - ре бемоль мажор – до мажор – ля мажор – ми мажор-ля минор – фа мажор – ре минор – ре мажор – соль мажор г.м). Гоцлоочоос хурууны жигд хүрэлт ихээр шаардана. Хэдий чанга эхэлнэ гэж бичсэн байгаа ч жигд чанга явахдаа холбоос болон аялгууг урсгаж чадахгүй бол этюд<sup>13</sup> адил болно. Тиймд хурдан бөгөөд холбоосоор аялгууг уянгалаг илэрхийлэх нь төгөлдөр хуурчийн ур чадвартай холбоотой. Жигд хүчтэй хуруугаар удаан давтахдаа аялгууг орхигдуулж болохгүй. Ноотны алдагдал үүсгэхгүйн тулд хурууны зөв хуваарилал хэрэгтэй. Айзам 1, 2-ын гурав, дөрөвдүгээр хувь дээр баруун гарын хурууны хуваарилал 5, 4, 3, 4 гэсэн дараалсан хөдөлгөөн жигд хурууны хөдөлгөөн шаардана. 5, 4, 3-р хурууны гоцлоочийн хувьд бэрхшээл саатал учирч болохуйц хуваарилал юм. Өөр хуваарилал сонгож болох авч хурдыг хөгжмийн зохиолч минутанд 108 цохилт бүхий дөрөвтэй тэнцүүлжээ. Тиймээс тус хуваарилал нь хамгийн ойр хугацаа алдахгүй очих сонголт юм.



Зураг 8. Айзам 1-4, 16-т ноотын жигд аялгуу

<sup>13</sup> Ихэнх тохиолдолд гарын дасгал бөгөөд хурууны хурдан хөдлөх чадварыг сайжруулах зорилготой.

Мөн гарт эвтэйхэн байх үүднээс 7-р айзмын 2 дахь хувийн ми, соль, до ми ноотыг баруун гараар хөгжимдөх нь зүйтэй байв. Үүнтэй ижил 11-р айзамд 1 дэх хувийн 4 дэх арван зургаатыг зүүн гар, 13 айзам 2 дахь хувийн до ноотыг баруун гар, 3 дахь хувийн ми ноотыг зүүн гар, 14 айзам мөн адил, 23 айзамд гуравлал (триоль) ноотуудыг баруун зүүн, баруун зүүн гэсэн 2 гарт хувааж хуваарилах нь ноот жигд алдагдалгүй болгох, гарт эвтэй, хурдны сааталгүй болж байна.



Зураг 9. Айзам 7-8, баруун гарт хамаарах хуваарилал



Зураг 10. Айзам 23, Баруун зүүн гарын хуваарилал (хөх-баруун, улаан-зүүн)


Тус прелюди нь романтизмын хэв шинж агуулж буй учир сэтгэлийн илэрхийллийг хүчдэлийн тэмдэг, өргөлт болон дуурьсгуурын зөв зохистой хэрэглээнд зохиолын утга санаа бүрэн илэрхийлэгдэнэ хэмээн үзэж байна. Дуурьсгуурыг зохиолын туршид өргөн, уртаар хэрэглэх ба хөг болон хам эгшиг солигдох бүрд цэвэрлэж байх нь зүйтэй.



Зураг 11. Айзам 17-25, шаардлагатай болон шаардлагагүй хүчдэлийн тэмдгүүд

22 айзамд зохиолч аяархан (p) тэмдэглэгээ тавьсан хэдий ч үүнийг бид төдийлөн шаардлагагүй хэмээн үзэж харин 17 айзамд буй бага багаар чангарч (poco a poco cresc.) төгсгөлийн огцом хүчтэй маш чанга (sff) руу ирэх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь 22 айзамд буй аяарыг хийснээр зохиолын жигд, хурдтай, эрчтэй хөдөлгөөн унаж төгсгөлийн 4 айзмын хооронд маш чанга дээр ирэх нь учир дутагдалтай болох юм.

Фуга (соль минор): Сэдэв аяны хувьд хөгжимдөх илэрхийллийг зохиолчийн тэмдэглэснээр *sempre cantabile* буюу энгийн дуулалтай гэсэн утгыг илэрхийлсэн байна. Тус илэрхийлэл зохиолтой нийцэж байна. Сэдэв ая маш цөөн ноотноос бүрдэх ба 2 айзам үргэлжилнэ.



Зураг 12. Айзам 1-2, сэдэв ая


Сэдэв аяыг бүх хоолойд “бодит хариу”-аар давтаж дууссаны дараа “бараг хариу” болгон “завсар хөгжим”-д сэдэв аяын материалыг ашигласан.

Зохиолын онцлог нь сэдэв ая болоод сэдэв аялгууны материал ихэд өөрчлөлттэй давтагдсан ба имитацийн аргыг түлхүү ашигласан байна.

Хөгжимдөх арга барилын асуудалд сэдэв аялгуу айзам бүрд тохиох ба түүнд анхаарлыг хандуулахын зэрэгцээ эсрэг сэдэв орж ирэх бүрд аялгууны бие даасан чанарыг алдуулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Хөгжимдөхөд хүнд хэцүү хэсэг харьцангуй бага ч эгшиглээний хувьд хоолой бүрийг ялгах хэсгүүд цөөнгүй бий.



Зураг 13. Айзам 6, зохиолын бэрх хэсгүүд, баруун гарт 2 хоолой



Зураг 14. Айзам 7-8, зохиолын бэрх хэсэг, баруун гарт сэдэв ая 1-р хуруугаар эсрэг сэдэв ая 2, 3, 4, 5-р хуруунд хуваарилгагдаж байна.

### Хэлэлцүүлэг

“Суралцах хүсэл эрмэлзэлтэй залуу хөгжимчдийн ашиг тус, хэрэглээнд зориулав. Мөн түүнчлэн энэ чиглэлээр хэдийнээ мэргэшсэн хүмүүсийн цагийг зугаатай өнгөрүүлэхэд зориулав” (И.С.Бах 1722, 1) хэмээн 1722 онд бичсэн их, бага 24 хөг бүхий Прелюди ба фуга зохиолоо “Das Wohltemperirte Klavier” (Жигдэлсэн хөгт даруулт хөгжим) гэсэн нэр өгсөн ба 20 орчим жилийн дараа ижил төрлийн хоёр дахь номыг эмхэтгэсэн бөгөөд энэ нь “Жигдэлсэн хөгт даруулт хөгжим”-ийн хоёрдугаар хэсэг хэмээн нэрлэгдэх болж нийт 48 прелюди ба фуга болсон. Тэрээр 400 гаруй фуга зохиосноос тус хоёр боть зохиол нь өнөөг хүртэл концертын болон сургалтын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгдэх чухал гарын авлага болсон байна. И.С.Бахын бүтээлд диатоник цомнолыг бүх хөгт ашигласан нь гарт эвтэй байдаг бол таван хөгт цомнолд бичигдсэн энэхүү зохиол харьцангуй эвтэй бус.

Г.Цэндоржийн Прелюди ба фуга зохиол нь пентатоник таван хөгт цомнолд туулгуурлаж сонгодог онол хэлбэрээр бичигдсэн. Зохиолыг төгөлдөр хуурч хөгжимдөхөд сонгодог арга барилаас онцлог гарын тавил шаардахаар байна. Хурууны хуваарилалыг сонгодог арга барилаас өөрөөр тааруулан хөгжимдөх шаардлагатай нь судалгааны явцад тодорч байна. Хөгжимдөх арга барил, онцлогийг хурууны дугаар, гарын байрлалд нийцүүлэн, хөгжмийн нюанс, хурд, хүчдэлийг зөв илэрхийлж чадвал зохиолын утга санаа, аялгыг бүрэн илэрхийлэх боломжтой.

### Дүгнэлт

Монголын мэргэжлийн урлагийн хөгжилд 1974 оноос эхлэн олон хоолойн ухааны анхны сурах бичгүүд хэвлэгдэн гарч төгөлдөр хуурын урлагт одоогоос 45 жилийн өмнө анхны олон хоолойн дээд хэлбэр болох фуга зохиогдсон нь бидэнд анхаарч үзүүштэй чухал ач холбогдолтой зүйл болсон байна. Гэвч олон жилийн туршид тус зохиолууд үл ашиглагдан сургалтын болоод концертын үйл ажиллагаанд идэвхгүй байсаар ирсэн. Б.Оюунбадрахын “Мэргэжлийн хөгжмийн боловсруулга” төслийн хүрээнд тус бүтээл судалгаа, уран бүтээлийн эргэлтэд орж А.Энх-Амгалан миний бие бүхэлд нь хөгжимдөж дүрсжүүлсэн билээ. Уг судалгааны шинэлэг тал нь Г.Цэндоржийн Прелюди ба фугийг бүхэлд нь авч үзсэн байх ба утга санааг алдагдуулахгүйн тулд хөгжимдөхөд эвтэйхэн болгох үүднээс гарын болон хурууны хуваарилал, олон хоолойн бүтэц, аялгууг зөв илэрхийлэх хоолойн бие даасан чанарыг хэрхэн алдагдуулахгүй хөгжимдөх зэрэг хөгжимдөх арга барилын судалгаанд тулгуурлав. Бид Г.Цэндоржийн Прелюди ба фуга дэс.59 №1, 2 зохиолыг судалснаар дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Дэс.59 №1 ми мажор, №2 соль минор Прелюди ба фуга нь зохиолчийн өөрийн тодорхой хэмжээний боловсруулгатай бөгөөд хуваариллын хувьд учир дутагдалтай нь ажиглагдсан. Энэ асуудалд төгөлдөр хуурч өөрийн хөгжимдөх арга барилд тулгуурлан хуваарилал хийж хөгжимдөхөд хялбар болгож байна.
2. Төгөлдөр хуурчаас монгол аялгууг илэрхийлэхэд эгшиглээний мэдрэмж, аялгууны хөдөлгөөнийг зөв илэрхийлэх ур чадвар шаардаж байна. Зарим тохиолдолд хөгжмийн зохиолчийн хурдны тэмдэглэгээг илүү хурдан болгох эсвэл эсрэгээр арай удаан болгох нь зүйтэй байна. Эдгээр нь

хөгжимчний сэтгэлгээ, мэдрэмж, чадвартай холбогдож байна. Гэхдээ ийнхүү өөрийн онцлогийг илэрхийлэхдээ эх бичвэртэй уялдуулан хэт өөрчлөхөөс зайлсхийх нь зүйтэй гэж үзсэн.

3. Тус зохиолууд өрнийн сонгодог онол, зохиомжоор зохиогдсон хэдий ч монгол ахуй сэтгэлгээ, аялгуу эгшиглэгээг бүрэн шингээсэн. Үүнд хамгийн гол шалгуур болох төгөлдөр хуурын өөрийн онцлог, төгөлдөр хуурдах урлагт бүрэн нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй. Пентатоник буюу 5 эгшигт цомнол нь гоцлоочид хуваариллын хувьд оноолт нь төгс нийцэхгүй ч гэсэн, ХХ зууны хөгжмийн зохиолчдын бүтээлийг ажиглавал дээрх байдал ижил ажиглагддаг. Иймд дээрх асуудлыг хөгжимчин өөрийн ур чадварын хүрээнд шийдвэрлэж болохоор байна.

### Ашигласан материалын жагсаалт

#### **Монгол хэлээр:**

Жанчив, Д. 1974. *Олон хоолойн ухаан: Чанд бичлэгийн контрапункт*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Жанчив, Д. 1976. *Олон хоолойн ухаан: Фуга*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Жандал, Т. 2006. *Олон хоолойн ухаан: Онолын үндэс*. Улаанбаатар.

Жанцанноров, Н. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Улаанбаатар.

Жанцанноров, Н. 2007. *Монголын хөгжмийн арван хоёр хөрөг: Сонатын аллегро*. Улаанбаатар: Адмон принтинг.

Оюунбадрах, Б. 2016. *Төгөлдөрхуурын зохиолыг боловсруулах асуудал*. Улаанбаатар: Мөрөөдлийн гурвалжин.

Энх-Амгалан, Алтансүх. 2022. “Г.Цэндорж - Прелюди ба фуга #1 ми мажор.” Хөгжмийн видео бичлэг, 2022 оны 10-р сарын 3. 02:52. Youtube, URL: <https://www.youtube.com/watch?v=imbdumFm6CM>.

Энх-Амгалан, Алтансүх. 2022. “Г.Цэндорж - Прелюди ба фуга #2 (нооттой).” Хөгжмийн видео бичлэг, 2022 оны 06-р сарын 2. 03:33. Youtube, URL: <https://www.youtube.com/watch?v=8xeKNFbAMZA>.

#### **Гадаад хэлээр:**

Bach, Johann Sebastian. 1722. *Das Wohltemperirte Klavier: Preface*. Köthen.

Drummond Pippa, Lasocki David. 2001. *Schickhardt, Johann Christian*. London: Oxford University Press.

Geiringer Karl. 1954. *The Bach Family: Seven generations of creative genius*. New York: Oxford University Press.